

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

### **Үндсэн хуулийн асуудлаар ард нийтийн санал асуулга явуулах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах зарчмын шинжтэй дор дурдсан өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэсүгэй.

1/ Монгол Улсад Ерөнхийлөгчийн болон парламентын засаглалын аль нь тохирох, гүйцэтгэх засаглалын тэргүүнийг Улсын Их Хурал томилдог бус ард түмэн сонгодог байх, гүйцэтгэх засаглалыг нийт ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгч тэргүүлэх, Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийг нэгэн зэрэг явуулах.

2.Ард нийтийн санал асуулгыг 2019 оны 10 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд улс орон даяар явуулахаар зарласугай.

3.Гадаадад байгаа Монгол Улсын иргэдээс санал авах ажиллагааг Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт 2019 оны 10 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

4.Ард нийтийн санал асуулга явуулах тухай хуулийн 6.2-т заасны дагуу санал асуулгын агуулгыг илэрхийлсэн асуулт, түүнд өгөх эсрэг утга бүхий хариултын хувилбарыг бэлтгэж батлуулахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/-нд, иргэдэд тайлбарлан таниулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж ажиллахыг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус даалгасугай.

5.Ард нийтийн санал асуулга явуулах болон энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдох бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

6.Ард нийтийн санал асуулгыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж явуулахыг Сонгуулийн ерөнхий хороо /Ч.Содномцэрэн/-нд даалгасугай.

7.Ард нийтийн санал асуулгын иргэний /сонгогчийн/ бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмж ашиглахыг тус тус зөвшөөрсүгэй.

8.Энэ тогтоолыг 2019 оны 09 дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

## **ГАРЫН ҮСЭГ**